



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/1117

Улаанбаатар хот

Усны газрын 2021-2024 оны стратеги  
төлөвлөгөөг батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Усны газрын стратегийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Уранчимэг/, Усны бодлого зохицуулалтын газар /Д.Мөнхбат/ -т үүрэг болгосугай.

САЙД



Н.УРТНАСАН

Байгаль орчин, аялал жуулчлалын  
сайдын 2021 оны 05 дугаар сарын 11-ны  
өдрийн 1/13 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УСНЫ ГАЗАР

УСНЫ ГАЗРЫН  
2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Төлөвлөгөөг баталсан:**

Төсвийн Ерөнхийлөн захирагч,  
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд



Н.Уртнасан

**Төлөвлөгөө боловсруулсан:**

Төсвийн Төвлөрүүлэн захирагч,  
Усны газрын дарга



Ш.Мягмар

2021 он  
Улаанбаатар хот

## Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга

Товчилсон нэрийн тайлал.....	2
Нэг. Нийтлэг үндэслэл.....	3
1.1 Практик хэрэгцээ, шаардлага.....	3
1.2 Бодлого, эрх зүйн үндэслэл.....	4
Хоёр. Мандатын шинжилгээ.....	5
Гурав. Алсын хараа.....	12
Дөрөв. Эрхэм зорилго.....	12
Тав. Орчны шинжилгээ.....	12
Зургаа. Стратегийн зорилго.....	19
Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги...	20
Найм. Стратегийн зорилго ба Усны газрын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал.....	28
8.1 Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт.....	29
8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд.....	30
Ес. Хавсралт.....	32

## Товчилсон нэрийн тайлал

АННБ	Аж ахуйн нэгж байгууллага
АН-ийн ЗД	Аймаг, нийслэлийн Засаг дарга
АН-ийн ЗДТГ	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
МСС	Мянганы сорилтын сан
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СГЗ	Сав газрын захиргаа
Сум, дүүргийн ЗДТГ	Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар
СЯ	Сангийн яам
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УГ	Усны газар
УННМТ	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮҮЗ	Усны үндэсний зөвлөл
УЦС	Усан цахилгаан станц
ХАА	Хөдөө аж ахуй
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЭХЯ	Эрчим хүчний яам

## Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1 Практик хэрэгцээ, шаардлага

Манай орны усны нөөц нь цаг хугацаа, орон зайн хувьд харьцангуй жигд бус тархсан, усны нөөцийн 70 орчим хувь нь нийт нутаг дэвсгэрийн 30%-д буюу хангайн бүсэд бүрэлдэн бий болдог. Гэтэл говь, тал хээрийн бүсэд ашигт малтмалын олборлолт эрчимжиж, аж үйлдвэрлэлийн гол түшиц газар болох хандлагатай байгаа хэдий ч өсөн нэмэгдэх усны хэрэгцээг хангаж чадахгүй усны хомстол нүүрлэх, улмаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг хязгаарлах нөхцөл байдал үүсч байна.

Манай орны жилийн дундаж агаарын температур сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд 2.25<sup>0</sup>C-ээр нэмэгдэж байгаа нь дэлхийн дунджаас даруй 3 дахин их байна. Уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж байгаа нь байгаль, цаг агаараас ихээхэн хараат байдаг эдийн засгийн салбаруудад үзүүлэх эрсдэл, дарамтыг улам бүр нэмэгдүүлж, гол ус, булаг шанд хатаж ширгэх, мөнх цас, мөсөн гол, цэвдэг, мөстөл хайлах, хөрс бэлчээр доройтон цөлжих, байгаль цаг агаарын аюулт үзэгдлийн давтагдал, эрчим, хамрах газар нутаг нэмэгдэх байдалд хүргэж байна.

Сүүлийн 20-иод жилийн хугацаанд томоохон голуудын урсац эрс багасч, жижиг гол горхи, нуур цөөрөм ширгэж, голуудын татам дагуух экологийн тэнцвэрт байдал алдагдаж, хуурайшилт хүчтэй явагдаж байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, өсөн нэмэгдэх усны эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн зорилт, арга хэмжээнүүдийг Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ирсэн. Хүн амын ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлыг жил бүр гүйцэтгэж, мөнх цас, мөсөн голын хайлсан усыг хуримтлуулан ашиглах хөв цөөрмийг өндөр уулын бүсэд жил бүр (3-аас доошгүйг) барьж байгуулах, булаг шандны эх үүсвэрийг хашиж хамгаалах ажлуудыг тасралтгүй зохион байгуулж гүйцэтгэж ирсэн.

Гэсэн хэдий ч эдийн засгийн салбаруудын өсөн нэмэгдэх усны хэрэглээг найдвартай хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон шат дараатай бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах асуудал хоцрогдсон хэвээр байна. Бодлогын түвшинд зорилго, үйл ажиллагааг төлөвлөсөн хэдий ч хэрэгжилт сул, усны нөөцийн нэгдсэн удирдлага төдийлөн бүрэн хангагдахгүй байна.

Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэн усны нөөцөд тулгуурласан ус хангамжийг нэгдсэн удирдлагаар хангах үүрэгтэй Усны газар нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 121 дүгээр тогтоолоор байгуулагдсан. Шинээр байгуулагдсан Усны газар нь "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол орны усны салбарт нэн тэргүүнд тулгамдсан асуудлыг "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, усны нөөцөд тулгуурласан менежментийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах" юм гэж үзсэн. Иймд 2021-2024 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд усны нөөцийг судалж тогтоох, нэмэгдүүлэх,

гадаргын усыг хуримтлуулан байгалийн урсцыг сэргээх, эдийн засгийн салбаруудын өсөн нэмэгдэх усны эрэлт хэрэгцээг найдвартай хангах төслүүдийг эхлүүлэх, ус хэрэглэгч, ашиглагч нарыг усны зохистой, хэмнэлттэй хэрэглээнд хэвшүүлэх механизмыг хэрэгжүүлэх, усны салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг шинэ шатанд гаргах гэсэн 5 зорилтыг тавьсан.

## 1.2 Бодлого, эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталж, уг баримт бичигт нийцүүлэн УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталж, урт, богино хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Усны салбарт өнөөгийн байдлаар усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой 15 хууль, олон улсын 2 гэрээ, 1 конвенц, 1 үндэсний хөтөлбөр, 1 менежментийн төлөвлөгөө зэрэг төрөөс усны нөөцийг хамгаалах талаар баримтлах бодлого, стратеги, хууль, тогтоомжийг Улсын Их Хурал, Засгийн газраар батлуулж, байгалийн нөөцийн ашиглалтыг эдийн засгийн үнэлгээ, төлбөртэй болгох, байгалийн нөөцийг ашиглагч нь хамгаалж, бохирдуулагч нь төлөгч байх зарчмыг хэрэгжүүлэхэд онцгойлон анхааран ажиллаж байна.

Усны салбарын ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт, богино хугацааны бодлогууд, салбарын бусад бодлогын баримт бичгүүд, Олон улсын гэрээ конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, стратегийг боловсруулж тусгасан.

2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасныг үндэслэн Усны агентлагийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримталсан.

Стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын өмнөх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр дэвшүүлсэн зорилтын биелэлтэд хийсэн дүн шинжилгээ, байгаль орчны салбарын бусад бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтын үр дүн, салбарын байгууллагуудаас хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг

сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөө, үр дүнг харгалзан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан тусгасан.

Энэхүү төлөвлөгөөг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрэх түвшинг баримтлан усны нөөцийг хамгаалах чиг үүргийн хүрээнд 5 зорилт, 22 арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлнэ. Дээрх зорилт, стратеги арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгууллага, сав газрын захиргаадын боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн болно.

## Хоёр. Мандатын шинжилгээ

Усны агентлагийн мандат, чиг үүргийн шинжилгээг хийхээс өмнө усны салбар, усны менежментэд үндэсний түвшинд оролцогчдыг товч дурдвал:

Засгийн газрын тухай хуулиар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого (Үндэсний хөгжлийн газар),

Ерөнхий чиг үүргийн яам болох Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах усны нөөцийн нэгдсэн бодлого, Гадаад харилцааны яаманд гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах (хилийн усны) асуудал, Сангийн яаманд төсөв, санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, Хууль зүй, дотоод хэргийн яаманд эрх зүйн шинэтгэлийн бодлого;

Чиглэлийн яам болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хөдөө аж ахуйг хөгжүүлэх (бэлчээр, тариалангийн усжуулалт) асуудал, Барилга, хот байгуулалтын яаманд хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ, Боловсрол, шинжлэх ухааны яаманд сургалт, судалгаа, боловсон хүчний асуудал, Зам, тээврийн хөгжлийн яаманд далай ашиглах болон усан замын тээврийн асуудал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүнд үйлдвэр, уул уурхайг хөгжүүлэх (уул уурхай, хүнд үйлдвэрийн ус хангамж) бодлого, Эрүүл мэндийн яаманд ундны усны чанар, эрүүл ахуйн асуудал, Эрчим хүчний яаманд сэргээгдэх эрчим хүч (УЦС)-ийг хөгжүүлэх шинэ эх үүсвэрийг бий болгох зэрэг асуудал хамрагдаж байна.

Дүгнэж хэлбэл, Засгийн газрын 11 яам устай холбоотой бодлого, хэрэгжилтэд шууд хамааран оролцож байна. Үндэсний түвшинд усны асуудлаар дээрх яамдуудыг бодлогоор удирдан, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий "Усны үндэсний зөвлөл"-ийг байгуулахаар Усны тухай хуулинд 2020.01.17-нд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан. Зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, нарийн бичгийн дарга нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд байна. Зөвлөлийг байгуулах, зөвлөлийн ажиллах дүрмийг боловсруулж батлах асуудал БОАЖЯ-ны чиг үүрэг бөгөөд Усны үндэсний зөвлөл нь ойрын үед байгуулагдаж, үйл ажиллагаа

нь жигдэрвэл усны асуудлаарх бодлогын түвшний салбар дундын зохицуулалт хангагдах болно.

Усны газар нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын өмнө усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, зохистой ашиглах, усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг шуурхай хүргэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Усны газрын мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль болон Усны салбарын шууд хамаарах 15 хуулийн (жагсаалтыг хавсаргав) хүрээнд усны салбарын байгууллагуудад хуулиар олгосон усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хамруулан авч үзэж, дараах дөрвөн алхмын хүрээнд шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор Усны газрын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах;
3. Салбар хоорондын болон засаглалын түвшинд холбогдогч талуудын оролцоог тодорхойлох;
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох.

Үндсэн чиг үүрэг: Салбарын бодлого, стратегийг боловсруулж батлах, хууль эрх зүйн орчныг сайжруулах-БОАЖЯ, УГ

- Журам, дүрэм, аргачлалын төсөл, санал боловсруулах-УГ
- Журам, дүрэм, аргачлал боловсруулах, батлах-БОАЖЯ
- Сав газрын хил хязгаар, сав газрын захиргааны бүтцийн төслийн санал боловсруулах-УГ
- Сав газрын хил хязгаарыг батлах, сав газрын захиргааны бүтцийг батлах-БОАЖЯ
- Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах-УГ
- Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах-УГ
- СГЗ даргыг томилох, чөлөөлөх-БОАЖЯ
- Бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулах-УГ

Үндсэн чиг үүрэг: Усны нөөцийг хамгаалах: нөөцийн төлөвлөлт ба хяналт-шинжилгээ-УГ

- Тодорхой бүс нутгийн гидрогеологийн болон гидрологийн хайгуул судалгаа, улсын зэрэглэлтэй хот, бусад хот, тосгон, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах шийдвэр гаргах –БОАЖЯ

- Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг батлах-БОАЖЯ, УГ
- Газрын доорх усны хайгуул судалгааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих-УГ
- Гидрогеологийн зураглал хийх ажлыг зохион байгуулах-УГ
- Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар бүрээр тогтоох санал боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих-УГ
- Газрын доорх усны чанарын, нөөцийн хяналт-шинжилгээ, мониторинг-УГ
- Сав газрын хяналт шинжилгээний сүлжээ ажиллуулах-СГЗ, аймгийн ЦУОШГ
- Гадаргын усны чанар, нөөцийн хяналт-шинжилгээ, мониторинг хийх-ЦУОШГ, УГ
- Усны нөөцийн төлөвлөлт буюу усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих-УГ, СГЗ
- Усны тоо бүртгэлийг зохион байгуулах-УГ,СГЗ
- Улсын мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих-БОАЖЯ
- Усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх, аргачлал, зааврын санал боловсруулах-УГ

Үндсэн чиг үүрэг: Ус ашиглалтыг зохицуулах, хяналт тавих: Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд үндэслэж, салбаруудын усны эрэлт, нийлүүлэлт ба Уур амьсгалын өөрчлөлт, устай холбоотой гамшгийн эрсдлийг тооцож, ус ашиглалтыг зохицуулах-УГ

- Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл, -УГ, СГЗ, орон нутгийн БОАЖГ
- Усны мэргэжлийн байгууллага эрх олгох, цуцлах- БОАЖЯ
- Томоохон гол мөрний урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах асуудлыг шийдвэрлэх-УҮЗ
- Голын голдирол өөрчлөх асуудлаар шийдвэр гаргах- БОАЖЯ
- Голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах-УГ
- Гадаадын иргэн аж ахуйн нэгжид ус ашиглуулахтай холбоотой шийдвэр гаргах-БОАЖЯ
- Бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах-УГ
- Стратегийн томоохон орд газарт цооног өрөмдөх, ус ашиглах судалгаа хийхэд дүгнэлт гаргах-УГ
- Ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох-УГ

Үндсэн чиг үүрэг: Усны нөөцийг нөхөн сэргээх, бохирдлыг бууруулах-БОАЖЯ, УГ, СГЗ

- Бохирдуулагч нь төлөх зарчим (хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл)-ыг хэрэгжүүлэх -УГ, СГЗ
- Бохирдуулагч эх үүсвэрийн бүртгэл хийх-УГ, СГЗ
- Ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих-УГ
- Усны чанарын болон хаягдал усны стандарт боловсруулах-БОАЖЯ
- Усан орчныг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах –БОАЖЯ
- Усан орчныг хамгаалах талаар улсын захиалга өгч судалгаа, шинжилгээ, зураг төслийн ажил гүйцэтгүүлэх- БОАЖЯ
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм тогтоох мөрдүүлэх- БОАЖЯ, БХБЯ, ИТХ
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах-СГЗ, бүх шатны Засаг дарга
- Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөө боловсруулах-СГЗ, аймаг, ЗД

Үндсэн чиг үүрэг: Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт хийх- УҮЗ, УГ, СГЗ

- Усны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын зөвлөмж гаргах-УҮЗ
- Ус ашиглагчдын хоорондох зөрчлийг шийдвэрлэх-СГЗ
- Салбаруудын ус ашиглалттай холбоотой бодлогыг тодорхойлох-УҮЗ
- Салбаруудын ус ашиглалттай холбоотой бодлогыг хэрэгжүүлэх, улсын дүн мэдээг нэгтгэх, зохицуулах-УГ

Үндсэн чиг үүрэг: Ус хангамжийн менежмент-БХБЯ, УГ

- Усыг олборлож, ариутгал халдваргүйжүүлэлт хийж түгээх- аймаг, нийслэлийн усаар хангагч байгууллагууд, УГ
- Хаягдал ус татан зайлуулах- аймаг, нийслэлийн усаар хангагч байгууллагууд, БХБЯ
- Хаягдал ус цэвэрлэх- аймаг, нийслэлийн усаар хангагч байгууллагууд, БХБЯ
- Үерийн ус, зам талбайн ус зайлуулах- АН-ийн ЗДТГ, ОБЕГ
- Төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж, түүний дотор толгойн байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах --“Монгол ус” ТӨААТҮГ
- Ус түгээлт, үйлчилгээний тариф тогтоох-БХБЯ, ХСУХАТАҮЗЗ

Үндсэн чиг үүрэг: Устай холбоотой эрсдлийг бууруулах /уур амьсгалын өөрчлөлт, ган гачиг, үерийн менежмент-ЦУОШГ

- Үер, ган гачигийн хяналт, шалгалт, үнэлгээ, судалгаа-ЦУОШГ, ОБЕГ
- Устай холбоотой эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ-ЭМЯ
- Усны эрсдлийг бууруулах, урьдчилсан сэргийлэх-ОБЕГ

- Эрсдлийн нөлөөллийг сааруулах-ОБЕГ

Үндсэн чиг үүрэг: Усны тоо бүртгэл, мэдээллийн сан-УГ, СГЗ

- Мэдээ цуглуулах-СГЗ, орон нутгийн БОАЖГ, УГ
- Хадгалах- УГ, СГЗ, орон нутгийн БОАЖГ
- Түгээх- УГ, СГЗ, орон нутгийн БОАЖГ
- Сурталчлах- УГ, СГЗ, орон нутгийн БОАЖГ

Үндсэн чиг үүрэг: Усны салбарын чадавх, хүний нөөцийг бэхжүүлэх-БШУЯ

- Хүний нөөцийн бодлогыг тодорхойлох-тодорхой бус
- Усны мэргэшсэн зөвлөх инженер бэлтгэх-УГ

Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой 9 үндсэн чиг үүрэг байгаа бөгөөд үүний 6 үндсэн чиг үүргийг Усны газар шууд хамааран гүйцэтгэж хэрэгжүүлнэ. 2 чиг үүрэгт нь 2 дахь оролцогч буюу БОАЖЯ, БХБЯ-тай хамтран хэрэгжүүлэгч болж байна. Харин усны салбарын чадавхи, хүний нөөцийг бэхжүүлэх асуудал БШУЯ-нд харьяалагдах хэдий ч усны мэргэшсэн зөвлөх инженер бэлтгэх, боловсон хүчний бодлогын тодорхойлох асуудал хуулиар зохицуулагдаагүй байна.

Усны нөөцийн хамгаалал, зохистой ашиглалттай холбоотой бодлогын асуудлыг БОАЖЯ, хэрэгжилтийг УГ хариуцаж байна. Ус хангамжийн менежментийн асуудлыг БХБЯ хариуцаж байна. Мөн устай холбоотой хэд хэдэн гол чиг үүргийг Засгийн газрын бусад агентлагууд хэрэгжүүлж байна. Үүнд: гадаргын усны судалгаа, нөөцийн асуудал БОАЖЯ-ны ЦУОШГ-т, үер усны гамшгаас сэргийлэх асуудлыг Засгийн газрын тохируулагч агентлаг ОБЕГ, устай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сахиулах чиг үүргийг МХЕГ гүйцэтгэж байна.

Дараах хүснэгтэд Усны газарт хуулиар олгогдсон ерөнхий болон үндсэн, дэд чиг үүргийг харуулав.

#### Мандатын шинжилгээний хүснэгт

<b>Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</b>		109
Үүнээс:	<b>Тухайн салбарын хуулийн тоо</b>	15
	<b>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</b>	94
<b>Ерөнхий чиг үүрэг-1: Усны нөөцийг бохирдол, хомстлоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангана.</b>		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</b>
<b>ҮЧҮ-1:</b> Усны нөөцийг хамгаалах,	1.Усны бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, норм, стандарт боловсруулах, төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх;	БОАЖЯ, УГ, СГЗ, ЦУОШГ

<p>бохирдол хомстлоос сэргийлэх, нөөцөд тулгуурласан оновчтой менежментийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтаар хангах</p>	<p>2.Усны нөөцийн нэгдсэн менежмент, сав газрын менежмент, салбар дундын зохицуулалт хийх;</p>	<p>БХБЯ, АН-ийн ЗДТГ, ХХААХҮЯ, УУХҮЯ, СЯ Сум дүүргийн ЗДТГ</p>
	<p>3.Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хамгаалалтад авах;</p>	
	<p>4.Усны хайгуул, судалгаа хийх ажлыг зохион байгуулах, зохицуулах, нөөцийг батлах;</p>	
	<p>5.Хот, суурины хүн амыг баталгаатай, эрүүл аюулгүй усаар хангах, ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг батлуулах;</p>	
	<p>6.Усны тоо бүртгэл, статистик мэдээлэл, кадастр, улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх;</p>	
	<p>7.Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах;</p>	
	<p>8.Усны сан бүхий газар, хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	
<p><b>ҮЧҮ-2:</b> Усны хуримтлал үүсгэж, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулсан, зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих</p>	<p>9. Усны нөөцийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх;</p>	<p>БОАЖЯ, УГ, СГЗ, ЦУОШГ БХБЯ, АН-ийн ЗДТГ, ХХААХҮЯ, УУХҮЯ, СЯ Сум дүүргийн ЗДТГ</p>
	<p>10.Усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих;</p>	
	<p>11.Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;</p>	
	<p>12.Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах;</p>	

	13. Бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах;	
<b>ҮЧҮ-3:</b> Хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах замаар хязгаарлагдмал усны нөөцийг хэмнэлттэй ашиглах бодлогыг хэрэгжүүлж, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх	14. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	БОАЖЯ, УГ, СГЗ, БХБЯ, АН-ийн ЗДТГ, Сум дүүргийн ЗДТГ
	15. Ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;	
<b>ҮЧҮ-4:</b> Усны салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах	16. Салбарын удирдлагын манлайллыг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;	БОАЖЯ, УГ, СГЗ
	17. Салбарын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах;	
	18. Хилийн усны гэрээ, хэлэлцээр болон бусад холбогдох конвенцийн хэрэгжилтийг хангах;	
	19. Санхүү, хөрөнгө оруулалтын төсвийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;	
	20. Үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхийг бэхжүүлэх.	

## Гурав. Алсын хараа

Нийгэм эдийн засаг дахь усны үнэлэмжийг нэмэгдүүлж, байгальд ээлтэй ус ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэн, Монгол улсын усны салбарын хөгжлийг тодорхойлогч байгууллага болно.

## Дөрөв. Эрхэм зорилго

Монгол улсын хүн ам, улс орны эдийн засгийг баталгаатай, хүрэлцээтэй усаар найдвартай хангаж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, экосистемийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, байгалийн үнэт баялаг болох усны нөөцөө хамгаалах, хэмнэлттэй, зүй зохистой ашиглах хандлагыг улс орон даяар хэвшүүлэхэд оршино.

## Тав. Орчны шинжилгээ

Усны газар нь Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлж, төр, иргэд, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд цаг үеэ олсон, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй, чанартай шуурхай хүргэхийн төлөө бүхий л боломж нөөцөө зориулан ажиллана.

Усны газрын 2021-2024 онд дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй гадаад ба дотоод орчны хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

**Зорилт 1. “Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулан нэмэгдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт**

ДОТООД ОРЧИН	
<b>Давуу тал</b> <ul style="list-style-type: none"><li>• Энэ ажлыг зохион байгуулах усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-УГ байгуулагдсан.</li><li>• УИХ-аас Алсын хараа 2050, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, ТХЗ 2030, МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт усны нөөцийн нэгдсэн</li></ul>	<b>Сул тал</b> <ul style="list-style-type: none"><li>• Шинээр байгуулагдсан усны газарт хуваарилах санхүүжилт бага. Иймд хайгуул судалгааны ажилд жил бүр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж, санхүүжүүлж байх шаардлагатай.</li><li>• Улсын төсөвт жил болгон 3-5 сумын төвийн усны эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлын төсвийн төсөөллийг оруулж санал хүргүүлдэг ч</li></ul>

<p>менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цогц зорилт, арга хэмжээ тусгагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийн сан, мониторингийн багаж, төхөөрөмж бүхий байнгын ажиллагаатай хяналтын систем бий болсон.</li> <li>• Хэлтэс, Сав газрын захиргаа, хувь хүмүүс хоорондоо хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харилцан солилцох, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах боломжтой.</li> <li>• Сав газрын түвшинд нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохицуулалт хийснээр усны нөөцийг хамгаалах ажилд санхүүжилт авах, салбарын ажлыг бусадтай хамтран гүйцэтгэх боломжтой.</li> </ul>	<p>2019 оноос хойш улсын төсөвт хөрөнгө хуваарилаагүй учраас хүн амыг найдвартай усаар хангах ажлыг зорилтод түвшинд хүргэх боломжгүй болох эрсдэлтэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>• УГ ба БОАЖЯ-ны чиг үүрэг давхцалтай байна. Усны тухай хуулинд газрын доорх усны хайгуул судалгааг хийх, шийдвэр гаргах, нөөц батлах ажлыг БОАЖЯ-ны үндсэн чиг үүрэгт заасан ч газрын доорх усны хайгуул судалгааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг Усны газарт олгогдсон байна. Чиг үүргийн давхцлыг тодорхой зохицуулахгүй бол энэ зорилгын биелэлт тодорхой түвшинд саарч болзошгүй.</li> <li>• Сав газрын түвшинд хяналт, мониторинг хийх хүний нөөц, техник, санхүүгийн чадавх сул байна. Иймд 21 СГЗ-дыг нэн тэргүүнд чадавхижуулах шаардлагатай байна.</li> </ul>
--	---

**ГАДААД ОРЧИН**

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нийцсэн бодлого, эрх зүйн орчин бүрдсэн.</li> <li>• Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг жил бүр Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой.</li> <li>• Хайгуулын ажлыг гүйцэтгэж чадахуйц боловсон хүчин, техникийн нөөцтэй мэргэшсэн усны мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ковид-19 цар тахлын улмаас улс орны эдийн засгийн өсөлт зогсч, усны салбарт хийх хөрөнгө оруулалт орж ирэхгүй байх эрсдэлтэй.</li> <li>• Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа.</li> <li>• Хөрөнгө оруулалтгүйгээр үр дүн, зорилтот түвшингийн гүйцэтгэлийг тайлагнах шаардлагатай болдог.</li> <li>• Улс төрийн тогтворгүй байдал</li> <li>• Гадаадын хөрөнгө оруулалт бага.</li> </ul>

**Зорилт 2. “Усны нөөцөд тулгуурласан хамгаалалт, ашиглалтын менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангаж усны нөөцийг бохирдохоос сэргийлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Энэ ажлыг зохион байгуулах усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-Усны газар байгуулагдсан.</li> <li>• УИХ-аас Алсын хараа 2050, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, ТХЗ 2030, МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ЗГ-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цогц зорилт, арга хэмжээ тусгагдсан.</li> <li>• Улсын усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээ байгуулагдсан бөгөөд мониторингийн цэгийн тоог жил бүр нэмэгдүүлж, нэгдсэн сүлжээнд холбох боломж бүрдсэн.</li> <li>• Мэдээллийн санг жил бүрийн усны тоо бүртгэлийн мэдээ, мэдээллээр тогтмол баяжуулж, шинэчлэх боломж бүрдсэн.</li> <li>• Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой.</li> <li>• 21 сав газрын захиргаадыг байгуулж, Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.</li> <li>• Сав газрын түвшинд нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохицуулалт хийснээр усны нөөцийг хамгаалах ажилд санхүүжилт авах, салбарын ажлыг бусадтай хамтран гүйцэтгэх боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сав газрын хэмжээний хяналт-шинжилгээний нэгж байгуулагдаагүй, зөвхөн газрын доорх усны нөөц, хяналт-шинжилгээ хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна.</li> <li>• Усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх, цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажлын зардлыг төсвийн тодотгол нэрээр тухайн ажлуудын зардлыг хасаж байгаагаас ажлын гүйцэтгэл бүрэн гарахгүй байна.</li> <li>• Сав газрын захиргаадад усны хяналт-шинжилгээний тоног төхөөрөмж, программ хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай.</li> <li>• Шинээр байгуулагдсан усны газарт хуваарилах санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.</li> <li>• Сав газрын захиргаадын хүний нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай техник хангамжаар хангахад ажлын төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй.</li> <li>• Сав газрын захиргаадад төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ажлын уламжлалыг хадгалах шаардлагатай.</li> <li>• Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Усны нөөцийн төлбөр жил бүр 45-47 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрдөг хэдий ч усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд хангалттай хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна.</li> </ul>

<b>ГАДААД ОРЧИН</b>	
<b>Боломж</b>	<b>Эрсдэл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Үйл ажиллагаагаа саадгүй явуулахад нийцсэн бодлого, эрх зүйн орчин бүрдсэн.</li> <li>• Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулахад усны нөөцийг хамгаалах ажлыг тусгуулах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ковид-19 цар тахлын улмаас улс орны эдийн засгийн өсөлт зогсч, усны салбарт хийх хөрөнгө оруулалт орж ирэхгүй байх эрсдэлтэй.</li> <li>• Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна.</li> <li>• Улс төрийн тогтворгүй байдал. Засгийн газар өөрчлөгдөх бүрт төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх зарчим хэрэгжихгүй, төрийн албан хаагчдыг солидог.</li> <li>• Гадаадын хөрөнгө оруулалт бага.</li> </ul>

**Зорилт 3. “Усны нөөцийн хомслоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Энэ ажлыг зохион байгуулах усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-Усны газар байгуулагдсан.</li> <li>• Өмнийн говийн ус хэрэглээг гадаргын усаар урт хугацаанд найдвартай хангах бүрэн боломжтой гэдгийг шийдвэр гаргагчид, бусад оролцогчид мэддэг болсон.</li> <li>• Хур тунадасны усыг хуримтлуулж бэлчээр болон газар тариаланг усжуулах зайлшгүй шаардлагатай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинээр байгуулагдсан усны газарт хуваарилах санхүүжилт бага.</li> <li>• Сав газрын түвшинд хяналт, мониторинг хийх хүний нөөц, техник, санхүүгийн чадавхи сул.</li> <li>• Усны барилга байгууламжийн инженер, зураг төсөл, төсөв зохиох мэргэжлийн боловсон хүчин дутмаг.</li> <li>• Ус хуримтлуулах чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны материал олдоц муутай, усны барилга байгууламжийн зураг төсөл, судалгаа нь хэрэгжихэд цаг хугацаа, хөрөнгө оруулалт их шаарддаг.</li> <li>• Бүтээн байгуулалтын ажилд хөрөнгө оруулалт, цаг хугацаа их шаардана.</li> <li>• Талууд хилийн усны асуудлаар бүрэн тохиролцоонд хүрээгүй.</li> </ul>

<b>ГАДААД ОРЧИН</b>	
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын түвшинд гадаргын усыг хуримтлуулах асуудлыг дэмжиж байгаа нь усны томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд санхүүжилт босгох боломжтой болж байна.</li> <li>• Томоохон ус ашиглагчдын урт хугацааны асуудлыг шийдвэрлэх тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой.</li> <li>• ICOLD буюу Олон улсын далан, боомт, урсцын тохируулга хийх зэрэг усны салбарт бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд мэргэжлийн болон техникийн туслалцаа үзүүлдэг байгууллагад гишүүнчлэлээр орсон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ковид-19 цар тахлын улмаас улс орны эдийн засгийн өсөлт зогсч, усны салбарт хийх хөрөнгө оруулалт орж ирэхгүй байх эрсдэлтэй.</li> <li>• Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэхгүй.</li> <li>• Улс төрийн тогтворгүй байдал.</li> <li>• Хилийн усны асуудлаар хөрш орнуудын зүгээс эсэргүүцэж, хэлэлцээр удааширнаас барилгын ажил эхлэхгүй байж болзошгүй.</li> <li>• Цар тахлаас үүдэлтэй улс орнуудын эдийн засгийн өсөлт саарч, гадаадын хөрөнгө оруулалт авахад удаашралтай, саад учирч болзошгүй.</li> </ul>

**Зорилт 4. “Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүнг нэгтгэх СВОТ хүснэгт**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>• Энэ ажлыг зохион байгуулах усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага-УГ байгуулагдсан.</li> <li>• Хаягдал усны асуудлыг хариуцсан нэгж бий болж, ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</li> <li>• Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг дагаж гарах бүх дүрэм, журам батлагдаж гарсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинээр байгуулагдсан усны газарт хуваарилах санхүүжилт бага.</li> <li>• Сав газрын түвшинд хяналт, мониторинг хийх хүний нөөц, техник, санхүүгийн чадавхи СГЗ-дад сул.</li> <li>• Усны газарт хаягдал усны чанарын лаборатори, дээж авах тоног төхөөрөмж байхгүй байна.</li> <li>• Иргэн, ААНБ-ын хаягдал ус хаях, зайлуулах мэдээлэл дутмаг.</li> <li>• Цэвэршүүлсэн бохир усыг эргүүлэн ашиглахад ААНБ-ын мэдээлэл дутмаг, хэрэглээ бага, зардал өндөр, зохицуулалтын механизм байхгүй.</li> </ul>

## ГАДААД ОРЧИН

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулагч нь төлөх зарчмыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн.</li> <li>• Хаягдал усыг дахин ашигласнаар усалгаатай газар тариалан эрхлэлт, аялал жуулчлалын салбарыг сурталчлах зэрэг ач холбогдолтой.</li> <li>• Ариун цэврийн байгууламжийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр эрүүл мэндийн эрсдэлийг бууруулна.</li> <li>• Хаягдал усыг эргүүлэн ашиглах нь усны нөөцийг хэмнэх, хаягдал усны чанарыг сайжруулах, технологийн шинэчлэл хийх, эдийн засгийн доройтолд орохоос сэргийлнэ.</li> <li>• МСС-ийн санхүүжилтээр Төв цэвэрлэх байгууламжаас ирсэн хаягдал бохир усыг гүн боловсруулж дулааны цахилгаан станцын хэрэглээнд ашиглах боломж бүрдсэн.</li> <li>• Төв цэвэрлэх байгууламжид ирж буй бохир усыг MNS 4943:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэх боломжтой, Ус дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх цэвэрлэсэн бохир усны чанарын шаардлагыг хангана.</li> <li>• Гадаадын туршлага, инноваци мэдээлэл нээлттэй байна.</li> <li>• Хувийн хэвшил, төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг босгох боломж байна.</li> <li>• Хаягдал усыг гүн боловсруулж, дулааны цахилгаан станцад өгснөөр саарал усны ашиглалтыг нэмэгдүүлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ковид-19 цар тархалт. Эм, эмнэлгийн байгууллагаас гарч буй хаягдал усанд тавигдах шаардлага, стандарт сул байгаа нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй байна.</li> <li>• Хаягдал бохир усаар дамжих өвчний тандалт мэдээлэл дутмаг байна.</li> <li>• Хаягдал усыг MNS 4943:2015 стандартын шаардлагад нийцүүлэхгүй байгальд шууд хаях тохиолдолд хүрээлэн буй орчин төдийгүй хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.</li> <li>• Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэхгүй.</li> <li>• Хаягдал бохир ус нь хөрсний шим тэжээлийг бууруулах, гүний усны бохирдлыг үүсгэх эрсдэлтэй.</li> <li>• Ариутгах татуургын сүлжээнд холбогдоогүй, УСУГ-тай гэрээ байгуулаагүй бохирдуулагчид хаягдал усаа эх үүсвэр нь тодорхой бус газарт зөөвөрлөн хаядаг.</li> <li>• Гэр хороолол, хувийн орон сууцыг ариутгах татуургын нэгдсэн системд холбох ажил бүрэн хийгдээгүй нь хүрээлэн буй орчны бохирдлын эх үүсвэр болж байна.</li> </ul>

**Зорилт-5. Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар салбарын хүний нөөцийг бүрдүүлэхэд мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.</li> <li>• Салбарын байгууллагуудын бүтэц чиг үүргийг ЗГ-аас тогтоож өгсөн.</li> <li>• Хилийн усны хэлэлцээрийг хэрэгжүүлэх механизм, үйл ажиллагаа тогтсон.</li> <li>• МУ-ын хэмжээнд төрөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгодог үйлчилгээг хялбарчлах, шат дамжлагыг багасгах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар нэгдсэн журмаар хэрэгжүүлж эхэлсэн.</li> <li>• Усны газрын албан хэрэг хөтлөлтийн E-Mongolia программ хангамжийг ашиглаж, иргэн аж ахуйн нэгж байгууллага болон төрийн байгууллагуудаас ирсэн албан бичгийг шийдвэрлэж байна.</li> <li>• Усны газрын цахим хуудсыг ажиллуулж, байнгын мэдээлэл түгээж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийгдээгүй.</li> <li>• Салбарт хэрэгжиж байгаа чиглэлийн бодлогын баримт бичгүүд дээр хүний нөөцийн асуудлыг тусгаснаас тухайлсан бодлого байхгүй.</li> <li>• Хүний нөөцийг чадавхижуулах асуудал хангалтгүй.</li> <li>• Хилийн усны хэлэлцээрийн хүрээнд хийгдэх зөвшилцөл, үйл ажиллагаа цаг хугацааны хувьд удаашралтай байна.</li> <li>• Мэдээллийн аюулгүй байдал сул.</li> <li>• Цахим технологид шилжсэнээр зарим тохиолдолд мэдээллийн үнэн бодит байдлыг шалгах, магадлах боломж хязгаарлагдмал.</li> <li>• Иргэн, ААНБ-тай харьцах нь ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй.</li> </ul>
<b>ГАДААД ОРЧИН</b>	
<b>Боломж</b>	<b>Эрсдэл</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн албаны зөвлөлийн зохион байгуулж байгаа төрийн албан хаагчдыг чадавхижуулах урт, дунд хугацааны сургалтад үе шаттайгаар албан хаагчдыг хамруулах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэлхий нийтийг хамарсан цар тахал, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж Улсын төсөвт хязгаарлалт хийгдэж, Усны салбарт шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх боломжгүй болох эрсдэлтэй. Тухайлбал, Сав газрын захиргааны албан хаагчдын тоог</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад, дотоодын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хүрээнд салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг хийх, системтэйгээр чадавхижуулах.</li> <li>• Салбарын байгууллагууд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.</li> <li>• Төрийн үйлчилгээг цахимжуулснаар иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх нөхцөл бүрдэнэ.</li> <li>• Бүх төрлийн мэдээлэл авах, түгээх үйл ажиллагааг хялбаршуулж цахимаар авах нөхцлийг бүрдүүлнэ.</li> </ul>	<p>нэмэгдүүлэх асуудал шийдэгдэхгүй байх.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангахтай холбоотой хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч болзошгүй.</li> <li>• Ковид-19 цар тахлын улмаас Хилийн усны хэлэлцээрийг зохион байгуулах боломжгүй, хуралдааныг хойшлуулж болзошгүй. Хэлэлцээрийг цахимаар явуулах нь төдийлөн тохиромжгүй байдаг.</li> <li>• Мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангаагүйгээс мэдээлэл алдагдах эрсдэлтэй.</li> </ul>
--	---

### Зургаа. Стратегийн зорилго

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу нийгэм эдийн засгийн өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг чанарын шаардлага хангасан баталгаатай, хүртээмжтэй усаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлж, цахим засаглалыг нэвтрүүлнэ.

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

**УСНЫ ГАЗРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Дэд	Бодлогын баримд бичигт үзэгдсэн боломжууд (Энгийн)	Стратегийн зорилго (Энгийн)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2019 он)	Зорилтот түвшин (2021-2024)	Сөрхүүлэн эх үүсвэр санхүүг	Хэрэгжүүлэх байдлыг дагуу
<p><b>Ерөнхий чиг үүргийн нэр: Усны нөөцийг бохирдол, хомстлоос хамгаалах, зохиистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангах</b></p>							
<p><b>Үндсэн чиг үүргийн нэр: Усны нөөцийг хамгаалах, бохирдол хомстлоох, эрэлт их оновчтой нөөцөд тулгуурласан менежментийг хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалтаар хангах</b></p>							
1.	Зорилт-1. Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулан нэмэгдүүлнэ.	Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх	1. Нөөц нь тогтоогдсон эх үүсвэрийн тоо 2. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	1. Нийт 332 сумын 190 төвийн нөөц нь тогтоогдсон 2. 82.5% /2018 оны суурь/	1. 210 /20-иор нэмэгдүүлнэ/  2. 84%	3,150.0 Улс, орон нутгийн төсөв, Төсөл хөтөлбөр	БОАЖЯ, УГ, СГЗ, БХБЯ, АН-ийн ЗДТГ
2.		Стратегийн ордууд, үйлдвэр, уул уурхайн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын судалгааг улсын болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт,	Томоохон үйлдвэр, уурхайн технологийн усны эх үүсвэрийн тоо	Жилд 5-7 баяжуулах үйлдвэрүүд, томоохон уурхайнуудын	Шинээр 20 эх үүсвэрт усны нөөцийг тогтооно	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	УГ, БОАЖЯ, ААН

		эрэлт хэрэгцээ, захиалгад үндэслэн хийж, газрын доорх усны ашиглах боломжит нөөцийг баталгаажуулах	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн эзлэх хувь	технологийн усны эх үүсвэрийг тогтоодог.		/Хувийн хэвшил/	
3.		Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн эзлэх хувь	14.8%	21%	2,400.0 Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	БОАЖЯ, УГ
4.	<b>Зорилт-2.</b> Усны нөөцөд тулгуурласан хамгаалалт, ашиглалтын менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангаж усны нөөцийг бохирдлоос сэргийлнэ.	Газрын доорх усны хяналт-шинжилгээ, хайгуул судалгаа, усны тоо бүртгэл, усны мэдээллийн сангийн холбогдох журам, аргачлалыг шинэчлэн боловсруулах	Шинэчлэн боловсруулсан аргачлал, журмын тоо	Хэрэгжиж байгаа 1 хөтөлбөр, 5 аргачлал, журам байна.	2 аргачлал, 3 журмыг шинэчлэн боловсруулсан байна.	50.0 Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	УГ, СГЗ, БОАЖЯ
5.		Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Хамгаалалтад авсан усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо	Улсын хэмжээнд 17 аймагт усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтад авсан.	21 аймаг, нийслэлийн усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтад 100% авсан байна.	100.0 Улс, орон нутгийн төсөв	УГ, СГЗ, АН-ийн ЗДТГ, БОАЖЯ
6.		Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох	Газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгийн тоо	274 цэг	334 цэг /60-аар нэмэгдүүлнэ/	3,000.0 Улсын төсөв, Бусад эх үүсвэр	УГ, СГЗ, АНЗДТГ

7.	Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах судалгаа хийх	Тусгай хамгаалалтад авах үндэслэл судалгааны тоо, цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн хэмжээ, хувь	49%	55% хүргэж нэмэгдүүлэх газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулах судалгааны ажилд оролцсон байна.	100.0 Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	УГ, СГЗ
8.	Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх	Жил бүр хашиж хамгаалсан булаг, шандны тоо	2860	Жил бүр 100-аас доошгүй булаг шандыг хамгаалж, хашиж хамгаалсан булаг шандыг 3460-д хүргэсэн байна.	2,000.0 Улс, орон нутгийн төсөв, Гадаадын зээл тусламж	АН-ийн ЗДТГ УГ, СГЗ, БОАЖЯ
9.	Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын хэсэгт ажиллаж, өгөгдсөн үүрэг даалгаврыг 100% биелүүлэх	Үүрэг даалгаврын биелэлт	-	Ажлын хэсэгт ажиллаж, өгөгдсөн үүрэг даалгаврыг 100% биелүүлсэн байна.	Төсөв шаардахгүй	УГ, СГЗ
10.	Улсын болон сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтаар хангах	Улсын болон сав газрын УННМТ-ний хэрэгжилтийн хувь	Улсын УННМТ-ний хэрэгжилт 21 сав газрын УННМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилт 67.4% байна.	УННМТ-г хэрэгжүүлэхэд талуудын оролцоог нэмэгдүүлж, хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.	150.0 Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	УГ, СГЗ

Үндсэн чиг үзэлийн нэр: Усны хуримтлал үсгэж, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулсан зохистой ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих						
11.	Зорилт-3. Усны нөөцийн хомстлоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцлийг бүрдүүлнэ.	Хэрлэн усан цогцолборын төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Ажлын зураг, БОНБНҮ, Барилга угсралтын ажлын үе шат	Хэрлэн-Тоонот усан цогцолбор төслийн ТЭЗҮ хийгдсэн.	Хэрлэн усан цогцолбор төслийн Ажлын зургийг хийж батлуулан, боомтын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	135,950.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж, Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Хувийн хэвшил/
12.		Онги голын урсцыг сайжруулах төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж бүтээн байгуулалтыг эхлүүлэх	БОНБНҮ, Ажлын зураг, Барилга угсралтын ажлын үе шат	Онги голын урсцыг сайжруулах төслийн ТЭЗҮ хийгдсэн	Онги голын урсцыг сайжруулах төслийн Ажлын зургийг хийж батлуулан барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	402,200.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж
13.		Гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулах	Жил бүр шинээр байгуулсан хөв цөөрмийн тоо	Улсын хэмжээнд баригдсан нийт хөв цөөрмийн тоо -36 (2017-2020 онд)	Жил бүр 3-аас доошгүй газарт шинээр байгуулж, хөв цөөрмийн тоог 12-оор нэмэгдүүлсэн байна.	3,600.0 Улс, орон нутгийн төсөв, Гадаадын зээл, тусламж

14.		Говь, хээрийн бүсэд газрын доорх усны ордын орчимд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, арга технологи нэвтрүүлэх	Шинээр туршиж хэрэгжүүлсэн арга технологийн тоо	Шинээр хийнэ.	Газрын доорх усыг зориудаар арвижуулах цөөрөм 2-3 сав газарт туршилтын журмаар барьж байгуулсан байна.	715.0 Төсөл хөтөлбөр	БОАЖЯ, УГ, СГЗ
<b>Үндсэн чиглэл: Шинээр Халдвал, Ус, Цэвэрлэх дахин ашиглах, эргүүлэн ашиглах замаар хэргээрлэгдсэн усны нөөцийг эмгэлтлэл</b>							
15.	Зорилт-4. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл	Хууль тогтоомж, стандарт, дүрэм, боловсруулах норм, журам	Боловсруулсан эрх зүйн баримт бичиг, стандарт нормын тоо	6	4	120.0 Төсөл хөтөлбөр	УГ, БОАЖЯ
16.		Бохирдуулагч эх үүсвэрүүдийн тооллого, судалгааг хийж, бүртгэлжүүлж, ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, урамшууллын механизмыг нэвтрүүлэх	Хамрагдсан аймаг, сум, бохирдуулагч эх үүсвэрийн тоо Тооллогын дүн мэдээ Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тушаал	Шинээр хийгдэнэ.	Сав газрын хэмжээнд бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг хийж, тайланг нэгтгэж, улсын усны нэгдсэн мэдээллийн санд хүлээлгэн өгсөн байна. Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх механизмыг нэвтрүүлж, хэвшүүлсэн байна.	80.0 Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	УГ, СГЗ, АН- ийн ЗДТГ

17.	ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	Усны хэрэглээг тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулах	Тоолууржуулалтанд хамрагдсан хувь	Тоолууржуулалт 75%	Хур тунадасны усыг хуримтлуулан ашиглахаас бусад тохиолдолд тоолууржуулалтын хувь хэмжээг нэмэгдүүлж, 78%-д хүргэсэн байна.	Төсөв шаардахгүй	УГ, СГЗ, АН-ийн ЭДТГ
18.		Үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, хаягдал усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх	Хаягдал усны дахин ашиглалтыг нэмэгдүүлсэн хувь	Уул уурхайн салбарт 70%, Бусад салбарт 5% байна.	Хаягдал усны дахин ашиглалт уул уурхайд 75%, бусад салбарт 8% хүрсэн байна.	Төсөв шаардахгүй	УГ, СГЗ
19.	<b>Үндсэн үзүүлэлт нэр / СГЗ салбарын үзэгдсэн үзүүлэлт</b>						
20.	Зорилт-5. Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг	Усны салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, хүний нөөцийг чадавхижуулах	Хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгаа Усны мэргэшсэн зөвлөх инженерийн сургалтыг жил бүр зохион байгуулна.	2016 оноос хойш Усны мэргэшсэн зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулаагүй.	Хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгаа хийж, тэргүүлэх чиглэлийг жил бүр тодорхойлно. Усны мэргэшсэн, зөвлөх инженерүүдэд зориулсан мэргэшүүлэх сургалтыг жил бүр 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.	Төсөв шаардахгүй	УГ

21.	<p>өргөжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх</p>	<p>Салбарын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлж, хөрш орнуудтай байгуулсан "Хиллийн усыг хамгаалах, ашиглах тухай" хэлэлцээрийг хэрэгжүүлэх</p>	<p>Хэлэлцээрийн хэрэгжилтийн хувь /жил бүрийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн хувь/</p>		<p>Гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг 60-аас доошгүй хувиар хангасан байна.</p>	<p>120.0 Улсын төсөв, төсөл хөтөлбөр</p>	<p>БОАЖЯ, УГ</p>
22.		<p>Усны газраас үзүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулан, онлайн хэлбэрт шилжүүлж, зардал бууруулах</p>	<p>Усны газраас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг 100% цахим хэлбэрт оруулсан байна.</p>	<p>Шинээр хийгдэнэ.</p>	<p>Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах үйлчилгээ, Усны хайгуул, судалгаа хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах үйлчилгээ, Аж ахуйн нэгж байгууллагуудын ус ашиглалтын тайлан хүлээн авах үйлчилгээ, Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээ, Усны барилга байгууламжийн төсөлд дүгнэлт гаргах үйлчилгээ, Хаягдал усны дүгнэлт гаргах үйлчилгээг цахимжуулсан байна.</p>	<p>50.0 Улсын төсөв, төсөл хөтөлбөр</p>	<p>УГ</p>

---000---



## Найм.Стратегийн зорилго ба Усны газрын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал


Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Усны газар” байгуулагдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/561 дүгээр тушаалаар “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” нь батлагдсан.

Усны газар нь бүтцийн хувьд дарга, дэд дарга, захиргаа, санхүүгийн асуудал хариуцсан Удирдлага, санхүүгийн хэлтэс, усны нөөц, төлөвлөлтийн асуудал хариуцсан Усны нөөцийн хэлтэс, ашиглалт, үйлдвэр техникийн асуудал хариуцсан Ус ашиглалтын хэлтэс, усны чанар, хяналт үнэлгээний асуудал хариуцсан Усны хяналт-шинжилгээний хэлтэс гэсэн 4 нэгжтэй. Усны газрын харъяанд сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, орон нутагт салбар дундын зохицуулалтыг хангах үндсэн чиг үүрэгтэй 21 сав газрын захиргаа ажиллаж байна.

Усны газар нь 38 хүний бүрэлдэхүүнтэй агентлаг байхаар батлагдсан ч өнөөдрийн байдлаар агентлагт 35 ажилтан, албан хаагч ажиллаж байна. 21 сав газарт нийт 200 албан хаагч ажиллаж байна.


Салбарын байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны уялдааг хангах нэгдсэн архитектур зураглалыг дараах байдлаар боловсруулж, бүтцийн схем 1, бүтцийн схем 2 –т тус тус оруулсан.

8.1 Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт



Бүтцийн схем 1

8.2 . Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд



Бүтцийн схем 2

